



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/115-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Гэрээгээр аудит гүйцэтгэсэн
Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар
Ахлах аудитор Ч.Анхбаяр
Утас: 8511-6555
Цахим хаяг: ankha964@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Төлбөрийн акт.....	11
5.2 Албан шаардлага	12
5.3 Зөвлөмж.....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 99

танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.МӨНХТӨР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль тайлант онд үдийн цай, хоолны зардал 83,843.6 мянган төгрөг, дотуур байрны хоолны зардал 71,354.6 мянган нийт 155,198.2 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд худалдан авсан;
2. Ээлжийн амралттай байх хугацаанд ажилтнуудад цалин бодож 7,547.5 мянган төгрөгийг илүү олгосон;
3. Албан хаагчдын ээлжийн амралтын хугацаанд цалин давхардуулан тооцож нийгмийн даатгал шимтгэлд 16,286.8 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварт 26,862.4 мянган төгрөгийг илүү шилжүүлж нийт 43,149.2 мянган төгрөгийн авлагын үүсгэсэн;

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, 16.5.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.5, 20.2.6, 20.2.7, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар 10.1, 34 дүгээр зүйлийн 34.1, 48 дугаар зүйлийн 48.2.1 заалтуудыг зөрчсөн, "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "Ерөнхий боловсрол" хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улс, орон нутгийн төсөв болон үйл ажиллагааны орлогоос нийт 2,915,971.3 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 2,669,436.2 мянган төгрөг буюу 91.17 хувьтай зарцуулж, төрийн сангийн дансанд 246,535.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн БШУГ-аас 94.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	282,619,411.21	390,951,551.14
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	159,064,643.38	246,535,164.52
312	Банканд байгаа бэлэн мөнгө	159,064,643.38	246,535,164.52
3121	Төгрөг	159,064,643.38	246,535,164.52
31211	Төрийн сангийн харилцах	159,064,643.38	246,535,164.52
33	АВЛАГА		50,696,704.94
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		50,696,704.94
35	БАРАА МАТЕРИАЛ	123,554,767.83	93,719,681.68
351	Түүхий эд материал	81,906,602.83	56,421,533.68
35110	Тусгай зориулалттай материал	76,210,452.83	51,726,033.68
35130	Эм боох материал	5,696,150.00	4,695,500.00
354	Хангамжийн материал	41,648,165.00	37,298,148.00
35410	Бичиг хэргийн материал	2,520,004.00	2,428,504.00
35420	Аж ахуйн материал	24,904,415.00	24,637,900.00
35450	Барилгын засварын материал	1,462,502.00	990,500.00
35460	Хүнсний материал	1,924,444.00	3,069,094.00
35470	Бусад хангамжийн материал	10,836,800.00	6,172,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,594,481,524.53	3,563,199,226.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,594,481,524.53	3,563,199,226.40
392	Биет хөрөнгө	3,550,053,524.53	3,518,771,226.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,697,337,015.17	3,697,337,015.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-423,541,101.07	-499,245,839.53
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	289,982,963.00	345,945,809.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-108,246,218.71	-123,394,460.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150,277,007.65	111,176,660.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	-92,190,184.05	-58,011,418.29
39217	Ном	36,434,042.54	44,963,460.54
393	Биет бус хөрөнгө	44,428,000.00	44,428,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,428,000.00	44,428,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,877,100,935.74	3,954,150,777.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,877,100,935.74	3,954,150,777.54
51	Засгийн газрын хувь оролцоо	3,877,100,935.74	3,877,100,935.74
511	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан орон нутгийн сан	729,557,051.50	729,557,051.50
512	Хуримтлагдсан үр дүн	2,159,488,517.02	2,236,538,358.82
51210	Өмнөх үеийн үр дүн	2,159,488,517.02	2,159,488,517.02
51220	Тайлант үеийн үр дүн		77,049,841.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	988,055,367.22	988,055,367.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,877,100,935.74	3,954,150,777.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,668,842,060.80	2,827,109,409.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	752,616,660.80	74,757,409.50
120	Нийтлэг татварын бус орлого	752,616,660.80	74,757,409.50
120004	Төсвийн байгууллага өөрийн орлого	5,076,600.00	4,409,700.00

Архангай аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120009	Бусад орлого	1,800.00	145,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	747,538,200.00	61,173,848.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		9,028,861.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,916,225,400.00	2,752,352,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,873,356,900.00	2,699,622,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,873,356,900.00	2,699,622,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,868,500.00	52,729,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,868,500.00	52,729,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,869,439,225.98	2,750,059,567.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,869,439,225.98	2,750,059,567.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,800,436,608.04	2,635,078,507.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,293,028,919.00	1,954,315,305.00
210101	Үндсэн цалин	913,600,032.00	1,194,650,675.00
210102	Нэмэгдэл	306,854,315.00	630,918,330.00
210104	Урамшуулал	72,574,572.00	128,746,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,750,677.62	236,020,656.37
210201	Тэтгэврийн даатгал	111,834,813.02	160,467,282.56
210202	Тэтгэмжийн даатгал	13,157,036.59	18,878,503.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,652,495.29	11,742,574.96
210204	Ажилгүйдлийн даатгал	2,464,004.49	8,986,453.11
210205	Эрүүл мэндийн даатгал	27,642,328.23	35,945,842.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,675,760.67	24,102,389.61
210301	Гэрэл, цахилгаан	12,125,760.67	23,729,334.98
210302	Түлш, халаалт	22,550,000.00	183,054.63
210303	Цэвэр, бохир ус		190,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,558,996.00	55,766,097.65
210401	Бичиг хэрэг	6,558,996.00	-
210408	Бараа материал акталсны зардал		55,766,097.65
2105	Нормативт зардал	159,580,861.39	71,354,550.00
210502	Хоол, хүнс	159,580,861.39	71,354,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,425,000.00
210604	Урсгал засвар		5,425,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		20,661,992.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,409,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		16,252,292.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,841,393.36	267,432,516.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,376,240.00	96,699,270.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,692,200.00	19,811,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,772,953.36	150,921,746.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,002,617.94	114,981,060.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	66,212,020.00	114,884,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,360,600.00	83,843,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,851,420.00	31,041,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,790,597.94	96,410.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,790,597.94	96,410.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	799,402,834.82	77,049,841.80
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	799,402,834.82	77,049,841.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,921,303,800.00</u>	<u>2,756,906,700.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,078,400.00	4,554,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,078,400.00	4,554,700.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,076,600.00	4,409,700.00
120009	Бусад орлого	1,800.00	145,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,916,225,400.00	2,752,352,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,873,356,900.00	2,699,622,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,873,356,900.00	2,699,622,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,868,500.00	52,729,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,868,500.00	52,729,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,781,429,636.62</u>	<u>2,610,970,578.86</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,781,429,636.62	2,610,970,578.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,658,163,988.68	2,500,494,418.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,305,486,958.62	1,971,106,168.62
210101	Үндсэн цалин	889,478,608.62	1148776159
210102	Нэмэгдэл	343,719,783.00	665,021,069.00
210104	Урамшуулал	72,288,567.00	157,308,941.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,761,258.00	266,477,497.69
210201	Тэтгэврийн даатгал	102,082,035.06	181,204,599.41
210202	Тэтгэмжийн даатгал	11,956,259.52	21,318,099.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,559,707.41	10,659,199.45
210204	Ажилгүйдлийн даатгал	2,378,158.51	10,659,199.57
210205	Эрүүл мэндийн даатгал	23,785,097.50	42,636,399.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,959,402.06	46,673,389.61
210301	Гэрэл, цахилгаан	13,009,402.06	23,729,334.98
210302	Түлш, халаалт	21,950,000.00	22,514,054.63
210303	Цэвэр, бохир ус		430,000.00
2105	Нормативт зардал	71,476,700.00	75,824,350.00
210502	Хоол, хүнс	71,476,700.00	75,824,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,118,500.00	5,960,000.00
210604	Урсгал засвар	5,118,500.00	5,960,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,124,200.00	24,976,592.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,076,600.00	4,409,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,047,600.00	20,566,892.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,236,970.00	109,476,420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,665,570.00	87,883,820.00

Архангай аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан			
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,571,400.00	21,592,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,265,647.94	110,476,160.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,475,050.00	110,379,750.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	91,751,250.00	75,889,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,723,800.00	34,490,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,790,597.94	96,410.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,790,597.94	96,410.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>139,874,163.38</u>	<u>145,936,121.14</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,054,000.00	58,465,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,054,000.00	58,465,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	41,054,000.00	58,465,600.00
223001	Бусад хөрөнгө	41,054,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		58,465,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-41,054,000.00</u>	<u>-58,465,600.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	98,820,163.38	87,470,521.14
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		159,064,643.38
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		246,535,164.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	729,557,051.50	988,055,367.22	2,159,488,517.02	3,877,100,935.74
C07	Тайлант үеийн үр дүн			-4,431,870.05	-4,431,870.05
D01	2023 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	729,557,051.50	988,055,367.22	2,159,488,517.02	3,877,100,935.74
D08	Тайлант үеийн үр дүн			77,049,841.80	77,049,841.80
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	729,557,051.50	988,055,367.22	2,236,538.82	3,954,150,777.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,927,824,400.00	2,669,339,768.47	258,484,631.53	91.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,927,824,400.00	2,669,339,768.47	258,484,631.53	91.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,803,044,200.00	2,558,960,018.47	244,084,181.53	91.29

Архангай аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,181,818,900.00	1,971,106,168.62	210,712,731.38	90.34
210101	Үндсэн цалин	1,385,478,400.00	1,148,776,158.62	236,702,241.38	82.92
210102	Нэмэгдэл	720,529,700.00	665,021,069.00	55,508,631.00	92.3
210104	Урамшуулал	75,810,800.00	157,308,941.00	-81,498,141.00	207.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	272,727,500.00	266,477,497.69	6,250,002.31	97.71
210201	Тэтгэврийн даатгал	185,454,600.00	181,204,599.41	4,250,000.59	97.71
210202	Тэтгэмжийн даатгал	21,818,100.00	21,318,099.70	500,000.30	97.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,909,200.00	10,659,199.45	250,000.55	97.71
210204	Ажилгүйдлийн даатгал	10,909,200.00	10,659,199.57	250,000.43	97.71
210205	Эрүүл мэндийн даатгал	43,636,400.00	42,636,399.56	1,000,000.44	97.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,729,800.00	46,673,389.61	56,410.39	99.88
210301	Гэрэл, цахилгаан	16,519,800.00	23,729,334.98	-7,209,534.98	143.6
210302	Түлш, халаалт	29,760,000.00	22,514,054.63	7,245,945.37	75.65
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	430,000.00	20,000.00	95.56
2105	Норматив зардал	81,545,300.00	75,824,350.00	5,720,950.00	92.98
210502	Хоол, хүнс	81,545,300.00	75,824,350.00	5,720,950.00	92.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	5,960,000.00	40,000.00	99.33
210604	Урсгал засвар	6,000,000.00	5,960,000.00	40,000.00	99.33
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,435,300.00	52,423,592.55	11,707.45	99.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,409,700.00	4,409,700.00	0.00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	48,025,600.00	48,013,892.55	11,707.45	99.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,787,400.00	140,495,020.00	21,292,380.00	86.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,194,800.00	118,902,420.00	21,292,380.00	84.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,592,600.00	21,592,600.00	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,780,200.00	110,379,750.00	14,400,450.00	88.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,780,200.00	110,379,750.00	14,400,450.00	88.46
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90,290,000.00	75,889,750.00	14,400,250.00	84.05
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,490,200.00	34,490,000.00	200.00	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,927,824,400.00	2,756,810,289.61	171,014,110.39	94.16
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,699,622,200.00	2,699,622,200.00	0.00	10
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,699,622,200.00	2,699,622,200.00	0.00	10
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,729,800.00	52,633,389.61	96,410.39	100
132001	Орон нутгийн төсвөөс	52,729,800.00	52,633,389.61	96,410.39	100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	175,472,400.00	4,554,700.00	170,917,700.00	2.51
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,409,700.00	4,409,700.00	0.00	100
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.00	145,000.00	11,855,000.00	
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	159,062,700.00		159,062,700.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		159,064,643.38	-	159,064,643.38
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		246,535,164.52	-	246,535,164.52
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	79	79	0	100
620001	Удирдах ажилтан	3	3	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	43	43	0	100
620003	Үйлчлэх ажилтан	33	33	0	100
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	845	845	0	100
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	845	845	0	100
630001	Төрийн өмчит ЕБС	845	845	0	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,954,315.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

- Тайлант онд цалингийн нэгдсэн системээс нийт 1,954,315.3 мянган төгрөгийн цалингийн журналын бичилтийг тулган шалгахад тооцооллыг журналд дутуу тусгасан, НДШ, ХХОАТ суутган тооцсон дүнгээс илүүгээр тайлагнаж төлбөр хийснийг НД Хэлтэс, Татварын хэлтэстэй тооцоо нийлж тайланг засах зэрэг залруулгыг хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 3.5 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2. "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Мөн аудитаар нийт **264,360.5** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, төсөвт төвлөрүүлэх 7,547.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчил таслан зогсоож, арилгуулах 5 албан шаардлага хүргүүлжээ.

Аудитаар залруулагдаагүй 7 зөрчилтэй асуудлын материаллаг бус алдаа зөрчил нь 213,663.8 мянган төгрөг, материаллаг алдаа зөрчил нь 50,696.7 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн **20,232.7** мянган төгрөг, материаллаг зөрчил нь их байгаа тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант жилд тус сургуулийн захирал, нягтлан бодогч, нярав нар нь ээлжийн амралттай байх хугацаанд 7,547.5 мянган төгрөгийн цалинг давхардуулан цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5.хариуцлагатай байх., 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7. "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэсэн заасныг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тус байгууллагын 2024 оны 3,563,199.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлээс өртгөө нөхсөн 21 нэр төрлийн 48 ширхэг 203,359.4 мянган төгрөгийн хөрөнгөнд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

5.2.2 Үдийн цай, хоолны зардал 83,843.6 мянга, дотуур байрны хоолны зардал 71,354.6 мянга нийт 155,198.2 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авах ажиллагааг байгуулаагүй бэлтгэн нийлүүлэгчтэй шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно." Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авч болох бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" харьцуулалт 20.0 сая төгрөгөөс дээш гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

5.2.3 2024 оны 8 сард ээлжийн амралттай байх хугацаанд ажилтнуудад цалин бодож олгосны улмаас жилийн эцэст НДШ-ийн 16,286.8 мянга, ХХОАТ-ын 26,862.4 мянга, нийт 43,149.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

5.2.4 Өмнөх аудитын зөвлөмжийн дагуу хөрөнгийг бараа материалаас үндсэн хөрөнгөнд шилжүүлэн бүртгэхдээ алдаа гаргаж үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлээс 3080.0 мянган төгрөгөөр илүү дүнгээр тайлагнасан буюу 1540.0 мянган төгрөгийн хөрөнгийг давхардуулан бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх, 15 дугаар зүйлийн 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", 20 дугаар зүйлийн 20.2.10 аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой.

Илрүүлэлт: Тайлант онд 58,465.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна., 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно."48.2.1.худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах; Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2-д "Энэ тогтоолын хавсралтаар тогтоосон төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалагч нарт, ... даалгасгай" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, материал, үндсэн хөрөнгө худалдан авахаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөж худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулах арга хэмжээг авч биелэлтийг хангаж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн журналын бичилт залруулсан	1	1,954,315.3			1	1,954,315.3	1	1,954,315.3				
Дүн	1	1,954,315.3			1	1,954,315.3	1	1,954,315.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Архангай аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шүүд гэрээгээр худалдан авалт хийсэн	1	155,198.2			1	155,198.2					
Шүүд гэрээгээр худалдан авалт хийсэн	1	58,465.6					1	58,465.6			
Авлага үүсгэсэн	1	43,149.2			1	43,149.2					
Үндсэн хөрөнгөнд давхар бүртгэснийг залруулах	1	3,080.0			1	3,080.0					
Үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж хугацааг сунгах	1	0			1	0					
Цалин илүү олгосон	1	7,547.5	1	7,547.5							
Дүн	6	267,440.5			5	201,427.4	1	58,465.6			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн	1	0			1	0		